




ХӨРСНИЙ ЭКОЛОГИЙН ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ (Судалгааны ажлын хялбаршуулсан үр дүн)

ШУА-ийн Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн Физик газарзүйн салбарын судлаачид 2017-2019 оны хугацаанд ШУТС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн ландшафтын экологийн чадавх” төслийн хүрээнд гарсан судалгааны үр дүнгээс “Шинжлэх ухаан, танин мэдэхүйн цуврал” мэдээлэл болгон танилцуулж байна.

Хөрсний экологи нь хөрсний биологи, биотик болон абиотик хүчин зүйлс хоорондын харилцан үйлчлэлийг судалдаг (David, 2004). Монгол орны хөрсний экологийн чадавхыг газарзүйн мэдээллийн систем дээр тулгуурласан олон шалгуурт шийдвэр гаргалтын аргыг (Multi criteria decision analysis) шаталсан дүн шинжилгээний аргатай (Analytical hierarchy process) хослуулах замаар тооцоолов.

Зураг 1. Хөрсний экологийн чадавхын нэгдсэн үнэлгээ



Судалгааны үр дүнгээс үзвэл нийт нутаг дэвсгэрийн 11.71% “маш сайн” ангилалд, “сайн” ангилалд 28.46%, “дунд” ангилалд 39.35%, “муу” болон “маш муу” ангилалд 20.48% нь тус тус орсон байна. Байгалийн бүс, бүслүүрүүдээр авч үзвэл ойг хээрийн бүсийн нийт талбайн 52.9 % нь, хээрийн бүсийн 33.0%, уулын тайгын бүслүүрийн 11.9%, говийн бүсийн 0.6%, өндөр уулын бүслүүрийн 0.3% нь маш сайн ангилалд багтаж байна. Хөрсний экологийн чадавхыг засаг захиргааны хуваариар авч үзвэл Дорнод, Сэлэнгэ, Булган, Хэнтий, Төв аймгуудад хөрсний экологийн чадавх хамгийн өндөр гарсан байна. Харин Баянхонгор, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Өмнөговь аймгуудад тааруу үнэлгээтэй газар нутаг үлэмж хувийг эзэлж байна (Зураг 1).




DIVISION OF PHYSICAL GEOGRAPHY

ASSESSMENT OF THE ECOLOGICAL POTENTIAL OF SOIL (Simplified result of the scientific research)

Researchers of the Division of Physical Geography, IGG, MAS are presenting the results of the research conducted within the framework of the project named “Assessment of the landscape-ecological potential of Mongolia natural zones” that was funded by the Science and Technology Foundation of Mongolia for the years 2017-2019 as “A Series of the Cognition and Science”.

Soil ecology studies the interaction between soil biology, biotic, and abiotic factors (David, 2004). The Ecological potential of soil was estimated by combining multi-criteria decision analysis based on the geographic information system with a hierarchical analysis method.

Figure 1. Assessment of the ecological potential of soil



Research results showed that 11.71% of the total territory is of “very high potential”, 28.46% has the “high potential”, and 39.35% has “moderate potential”. Also, 20.48% of the total territory in the “low” and “very low” soil ecological potential. In terms of natural zones, 52.9% of the forest-steppe zone, 33.0% of the steppe zone, 11.9% of the mountain taiga zone, 0.6% of the Gobi zone, and 0.3% of the high mountain zone are in the “very high” soil ecological potential. According to the administrative unit, soil ecological potential was “very high” in Dornod, Selenge, Bulgan, Khentii, and Tuv aimags while it was “very low and low” in Bayankhongor, Gobi-Altai, Bayan-Ulgii, Khovd, and Umnugovi aimags (Figure 1).